



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/47

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 35.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хишиг намуун далай” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Буурлуудын 4-н замын уулзварын гэрлэн дохио, Тарвастай 4-н замын уулзварын гэрлэн дохионы ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Гишүүд: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Ганзориг

- Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Б.Пүрэвдорж

- Хот тохижуулах газрын дарга

У.Пүрэвдорж

- Ховд Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний дарга

С.Батдорж

- Аймгийн архивын тасгийн дарга

И.Гантогтох

- Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах байцагч, цагдаагийн хошууч

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Т.Батцэцэг - “Хишиг намуун далай” ХХК-ний захирал

Нарийн бичгийн

дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. Буурлуудын 4-н замын уулзварын гэрлэн дохио, Тарвастай 4-н замын уулзварын гэрлэн дохионы ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Баярсүх)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН